



118

# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

## Т О Г Т О О Л

1989 оны 6 дугаар  
сарын 22-ны өдөр

Дугаар 152

Улаанбаатар  
хот

Улаанбаатар хотын аж ахуй, нийгэм соёлын салбарын удирдах байгууллагуудыг өөрчлөн байгуулах, АДХ-ын гүйцэтгэх захиргааны удирдлагын орон тоо, аппаратын бүтэц, цалингийн фондыг батлах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Төлөвлөгөөний комисс, Статистикийн хэлтэс, Үнэ, чанарын хэлтсийг нэгтгэн Төлөвлөгөө, эдийн засгийн хэлтэс; Хуулийн хэлтэс, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх улсын арбитрыг нэгтгэн Хотын хууль зүй, арбитрын хэлтэс; Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд Хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон сууц хуваарилалтын тасгийг тус тус байгуулсугай.

2. Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Хөдөө аж ахуйг удирдах газар, Ардын боловсролын удирдах газар, Эрүүлийг хамгаалах газар, Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс, Соёлын хэлтэс, Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс, Захиргаа, аж ахуйн хэлтсийг тус тус Хотын хөдөө аж ахуйг удирдах газар, Ардын боловсролын удирдах газар, Эрүүлийг хамгаалах газар, Соёлын хэлтэс, Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс, Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Хөдөлмөр зохицуулах товчоо, Аж ахуйн хэлтэс болгосугай.

3. Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Худалдааны хэлтэс, Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтсийг татан буулгасугай.

4. Улаанбаатар хотын Ардын боловсролын удирдах газар, Ахуйн үйлчилгээний удирдах газар, Байгаль, орчныг хамгаалах газар, Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар, Тээврийг удирдах

газар, Хууль зүй, арбитрын хэлтэс, Хот тохижуулах газар, Ус сувгийн ашиглалтыг удирдах газар, Хөдөө аж ахуйг удирдах газар, Төлефон, радио ашиглалтын хороо, Эргүүлийг хамгаалах газар, Соёлын хэлтэс, Нийтийн хоолны удирдах газар, Биеийн тамир, спортын хороо, Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл, Хүнсний бараа худалдааны нэгдэл, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Төлөвлөгөө, эдийн засгийн хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Цэргийн хэлтсийг хотын хэмжээнд улс ардын аж ахуй, нийгэм соёлын тухайн салбарыг эрхлэн удирдаж байхаар тогтоосугай.

5. Батлагдсан цалингийн фондоод нь багтаан хотын газрын дотор хэлтэс, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хэлтсийн дотор тасаг байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэж байх эрхийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд олгосугай.

6. Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны удирдлагын орон тоог дарга I, нэгдүгээр орлогч дарга I, орлогч дарга 3, хариуцлагатай нарийн бичгийн дарга I байхаар тогтоосугай.

7. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны аппаратыг Зохион зааварлах хэлтэс, Төлөвлөгөө, эдийн засгийн хэлтэс, Санхүүгийн хэлтэс /хянан байцаах тасагтай/, Хөрөнгө оруулалтын хэлтэс, Хөдөлмөр зохицуулах товчоо, Цэргийн хэлтэс, Аж ахуйн хэлтэс, Орон сууц хуваарилалтын тасагтай байхаар тогтоосугай.

8. Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд 1989-1990 онд мөрдөх сарын цалингийн фондыг 77,3 мянга /далан долоон мянга гурван зуун/ төгрөгөөр, гүйцэтгэх захиргааны дарга, орлогч дарга, хариуцлагатай нарийн бичгийн дарга нарын ажлын үлгэрчилсэн хуваарийг I дүгээр хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Энэхүү үлгэрчилсэн хуваарийн дагуу гүйцэтгэх захиргааны удирдах ажилтны ажлын хуваарийг баталж мөрдүүлэхдээ тэдний мэргэжил, ажлын онцлогийг харгалзан зохицуулалт хийж байхыг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.МӨНХЖАРГАЛ/-д зөвшөөрсүгэй.

3.

9.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2 дугаар хавсралтад дурдсан Сайд нарын Зөвлөлийн тогтоол, захирамж, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



БНМАУ-ын Сайд нарын  
Зөвлөлийн орлогч дарга

Б.АЛТАНГЭРЭЛ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн  
Хэрэг эрхлэх газрын дарга

З.СААРАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ДАРГА, ОРЛОГЧ ДАРГА, ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧ-  
ГИЙН ДАРГА НАРЫН АЖЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ХУВААРЬ

Нэг. Дарга

1. Хотын АДХ-ын гүйцэтгэн захирамжлах байгууллагуудын ажлыг нэгтгэн удирдаж, гүйцэтгэх захиргааг толгойлно.

2. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ардын хянан шалгах болон олон нийтийн байгууллагатай харилцан ажиллах асуудал.

3. Төсөв, санхүү, банк, улсын даатгал, тэтгэвэр тэтгэмжийн асуудал.

4. Улсыг батлан хамгаалахад туслах ажил.

5. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас анхан шатны АДХ-ын гүйцэтгэх захиргааг удирдах ажил.

6. Хотын аж ахуй, нийгэм-соёлын нийт салбарын хөгжлийг уялдуулах замаар хөдөлмөрчдийн төрөл бүрийн үйлчилгээг сайжруулах ажил.

7. Хууль зүй, арбитрын ажил.

8. Төрийн захиргааны боловсон хүчний асуудал.

Хоёр. Нэгдүгээр орлогч дарга

1. Төлөвлөлт, статистик, үнэ, чанар, стандарт, хөдөлмөр, цалин хөлс, материал-техникийн хангамжийн асуудал.

2. Шинжлэх ухаан-техникийн ололт, шинэ бүтээл, оновчтой санал, тэргүүн туршлагын асуудал.

3. Худалдаа, бэлтгэл, нийтийн хоолны салбар.

4. Зам, тээврийн салбар.

5. Хүн ам зүйн асуудал.

6. Хөдөлмөрийн хоршоолол, иргэдээс хувиараа хөдөлмөр эрхлэх асуудал.

## 2.

7.Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилготой программыг хэрэгжүүлэх асуудал.

8.Хөнгөн үйлдвэрийн салбар.

9.Байгаль, орчныг хамгаалах асуудал.

10.Үйлдвэр, албан газар, байгууллагын туслах аж ахуй, иргэдийн амины аж ахуйг хөгжүүлэх асуудал.

II.Хүнс, барааны захын асуудал.

Гурав.Орлогч дарга бөгөөд барилгын удирдах газрын дарга

1.Хөрөнгө оруулалт, их барилга, барилгын материалын үйлдвэр, барилгын захиалга, засварын асуудал.

2.Зам, талбай, далан сувгийн барилга байгууламжийн асуудал.

3.Архитектур, хот төлөвлөлтийн асуудал.

4.Газар эдэлбэр, олголт, ашиглалтад тавих хяналт.

Дөрөв.Нийгэм, соёл эрхэлсэн орлогч дарга

1.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудал.

2.Ардын боловсролын салбар.

3.Соёл, урлагийн салбар.

4.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх асуудал.

5.Улсын асрамжийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээг сайжруулах асуудал.

Тав.Орон сууц, нийтийн аж ахуй, хот тохижуулалт эрхэлсэн орлогч дарга

1.Орон сууц, нийтийн аж ахуйн салбар.

2.Ахуйн үйлчилгээний салбар.



3. Холбооны салбар.

4. Орон сууцны хуваарилалт, ашиглалт, цахилгаан, дулаан, ус суваг, усан хангамжийн асуудал.

5. Хот тохижуулалтын асуудал.

6. Гадаадын мэргэжилтний үйлчилгээний асуудал.

7. Түлшний мод бэлтгэх, борлуулах асуудал.

Зургаа. Хариуцлагатай нарийн бичгийн дарга

1. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас Хурлын бусад байгууллагатай харилцан ажиллах асуудал.

2. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны болон түүний аппаратын ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх захиргааны аппаратыг толгойлно.

3. Гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчилтэй тэмцэх асуудал.

4. Хөдөлмөрчдийн сайн дурын байгууллагыг удирдах асуудал.

5. Район, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас иргэдтэй ажиллах асуудал.

6. Иргэдийн шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр зохицуулалтын асуудал.

7. Гэрлэх ёслол, иргэний гэр бүл, иргэдийн үйлчилгээний асуудал.

8. Хотын гадаад харилцааны асуудал.

9. Улсын архивын ажил.

10. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны төсөв, аж ахуйн асуудал.



124

Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 152

Тогтоолын 2 дугаар хавсралт

АНГМ

**САЙД НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ  
ТОГТООЛ, ЗАХИРАМЖ, ТЭДГЭЭРИЙН ЗААЛТ**

1. "Нийслэл Улаанбаатар хотын захиргаанд хөдөлмөрийн хэрэг эрхлэх хэлтсийг байгуулах тухай" 1945 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 23 дугаар хурлын тогтоол.

2. "Техникийн хэлтэс байгуулах тухай" 1957 оны I дүгээр сарын II-ний өдрийн 8 дугаар тогтоол.

3. "Улсын банкны 1959 оны жилийн тайлангийн тухай" 1960 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 327 дугаар тогтоол.

4. "Мод тарих туршлагын газрыг шилжүүлэх тухай" 1960 оны 12 дугаар сарын 2I-ний өдрийн 54I дүгээр тогтоол.

5. "Орон тоо нэмэгдүүлэх тухай" 1960 оны II дүгээр сарын 2-ны өдрийн 35I дүгээр захирамж.

6. "Зарим эмнэлгийн газрыг хотын гүйцэтгэх захиргаанд харьяалуулах тухай" 1962 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 199 дүгээр тогтоол.

7. "Хотын гүйцэтгэх захиргаанд орлогч даргын орон тоо нэмэгдүүлэх тухай" 1964 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 106 дугаар тогтоол.

8. "Улаанбаатар хотод батлан хамгаалах хөдөлмөр нийгэмлэгийн штаб байгуулах тухай" 1965 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 6I дүгээр тогтоол.

9. "Орон тоо нэмэгдүүлэх тухай" 1965 оны 9 дүгээр сарын I-ний өдрийн 327 дугаар тогтоол.

10. "Орон тоо бий болгох тухай" 1972 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 329 дүгээр тогтоол.

II. "Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тоонд зарим өөрчлөлт оруулах тухай" 1976 оны II дү-

гээр сарын 12-ны өдрийн 387 дугаар тогтоолын 2 дугаар зүйл.

12. "Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тоог батлах тухай" 1978 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 294 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл.

13. "Улс ардын аж ахуйн хууль зүйн албаны талаар авах зарим арга хэмжээний тухай" 1979 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 101 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл.

14. "Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйг удирдах газрын зохион байгуулалт, орон тооны тухай" 1979 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 391 дүгээр тогтоол.

15. "Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Эрүүлийг хамгаалах газар, түүний харьяа зарим больницын зохион байгуулалтын тухай" 1980 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 329 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл.

16. "Улаанбаатар, Эрдэнэт хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны эрүүлийг хамгаалах газрын зохион байгуулалт, орон тоог батлах тухай" 1982 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 176 дугаар тогтоол.

17. "Батлан хамгаалах яамны төв аппарат, түүний харьяа зарим байгууллагын орон тоо, цалингийн схемд өөрчлөлт оруулах тухай" 1983 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 165 дугаар тогтоолын 2 дугаар зүйл.

18. "Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хүсэлтийн тухай" 1984 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 136 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл.

19. "Аймаг, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтын бүтэц, сарын цалингийн фондыг батлах тухай" 1987 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 82 дугаар тогтоолын гуравдугаар зүйл.